



## -ийг хамгаалах **Үндэсний** ба **Олон улсын** механизм

1993 оны Дэлхийн хүний эрхийн бага хурлаар баталсан Венийн тунхаглалд “Хүний эрх бол бүх хүнд заяасан төрөлх эрх бөгөөд хүний эрхийг хамгаалах нь төр засгийн байгууллагуудын анхдагч үүрэг юм” хэмээсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан билээ.

# ХЭ-ийн талаар төрийн хүлээх үүрэг

Хангах

Хамгаалах

Ахиц дэвшил  
гаргах

Хүндэтгэх



Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах нь төр засгийн сайн санааны үйлс бус, харин Үндсэн хуулиар төр засагт ард түмнээс ногдуулсан үүрэг юм.

Төр нь дотооддоо хүний эрхийг хангахдаа өөрийн тогтолцоог сайтар ажиллуулах үүрэг хүлээдэг. Эдгээр тогтолцоог нийтэд нь хүний эрхийг хамгаалах төрийн механизм хэмээн нэрийдэж байна.

## Төрийн хүний эрхийг хамгаалах чиг үүрэг

Хууль тогтоох

Гүйцэтгэх

Шүүх



# Үндэсний ТОГТОЛЦОО



```
graph TD; A[Үндэсний ТОГТОЛЦОО] --> B[Төрийн байгууллагууд]; A --> C[Хүний эрхийн үндэсний байгууллагууд]; A --> D[Иргэний нийгмийн байгууллагууд];
```

Төрийн  
байгууллагууд

Хүний эрхийн  
үндэсний  
байгууллагууд

Иргэний  
нийгмийн  
байгууллагууд

## 4 дүгээр зүйл.Шүүхийн эрхэм зорилго

4.1. Шүүх нь дараах эрхэм зорилготой:

4.1.1.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох;

4.1.2.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллыг хамгаалах;

4.1.3.хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх;

4.1.4.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх.

4.2.Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож болохгүй.

